

НЭГ. SOCIALPAY аппликэйшн ерөнхий ойлголттой холбоотой

- 1.1 SocialPay гэж юу вэ?
- 1.2 Үйлчилгээний нөхцөл
- 1.3 Аппликэйшн хэрхэн татаж авах вэ?
- 1.4 Хэрхэн бүртгүүлэх вэ?
- 1.5 Гадаад улсын иргэн онлайнаар бүртгүүлж болох уу?
- 1.6 Ямар сувгуудаар дамжуулан онлайнаар бүртгүүлэх боломжтой вэ?
- 1.7 Хэрхэн нэвтрэх вэ?
- 1.8 Сошиал данс гэж юу вэ?
- 1.9 Ямар данс холбож болох вэ?
- 1.10 Сошиал пин гэж юу вэ?
- 1.11 SocialPay-ээр шилжүүлсэн мөнгө болон нэхэмжлэхийн талаар нөгөө хүн маань яаж мэдэх вэ?
- 1.12 Нэхэмжлэхийг хэдэн хүн рүү илгээж болох вэ?
- 1.13 Мөнгө илгээх нэхэмжлэл илгээхэд гүйлгээний лимит байгаа юу?

ХОЁР. SOCIALPAY аппликэйшн хувин тохиргоотой холбоотой

- 2.1 Утасны дугаар, дансны дугаар зэрэг мэдээллээ яаж өөрчлөх вэ?
- 2.2 Нөгөө хүнийхээ дансны дугаарыг мэдэж байвал мөнгө шилжүүлж болох уу?
- 2.3 Утасны дугаараар мөнгө шилжүүлэхэд тухайн хүнийхээ мэдээллийг хадгалсан байх шаардлагатай юу?
- 2.4 Олон данстай хүн рүү мөнгө шилжүүлбэл аль данс руу нь орох вэ?
- 2.5 Дугаараа сольж өөр дугаар баривал над руу шилжүүлсэн мөнгө өөр хүнд очих уу?
- 2.6 Буруу утасны дугаар руу мөнгө илгээвэл яах вэ?
- 2.7 Харилцагчид төлбөрийн мэдээлэл апп-д бүртгэлтэй утасны дугаараар ирэх үү эсвэл интернэт банканд бүртгэлтэйгээр үү?
- 2.8 Сошиал дансандаа мөнгөгүй бол яаж орлого хийх вэ?
- 2.9 Гүйлгээний лимитээ яаж нэмэгдүүлэх вэ?
- 2.10 Дансны хуулга, сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээллээ яаж харах вэ?

ГУРАВ. SOCIALPAY аппликэйшн дээр гарч болзошгүй асуудал, хязгаарлалт, алдаатай холбоотой

- 3.1 Social Pin кодоо мартвал яах вэ?
- 3.2 Утсаа алдсан тохиолдолд, миний дансыг гадны этгээд ашиглах боломжтой юу?
- 3.3 Бүртгүүлсэн утасны дугаар маань өөр хүний данстай холбоотой байвал яах вэ?

ДӨРӨВ. ОНЛАЙН БҮРТГЭЛ ерөнхий ойлголттой холбоотой

- 4.1 Онлайн бүртгэл гэж юу вэ?
- 4.2 Үйлчилгээний онцлог
- 4.3 Үйлчилгээний нөхцөл
- 4.4 Ямар сувгуудаар дамжуулан онлайнаар бүртгүүлэх боломжтой вэ?
- 4.5 Гадаад улсын иргэн онлайнаар бүртгүүлж болох уу?
- 4.6 Онлайнаар бүртгүүлэх хүсэлтэнд маань хариу өгөхгүй бол яах вэ?

ТАВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ-тэй холбоотой

- 5.1 Нэмэлт үйлчилгээ цэсэнд ямар үйлчилгээ байдаг вэ?

- 5.2 Хамт олон буюу хамт олны данс гэж юу вэ?
- 5.3 Хүслийн хадгаламж гэж юу вэ?
- 5.4 Найзаа уривал ямар урамшуулалтай вэ?
- 5.5 Мини апп жагсаалт хэсэгт ямар үйлчилгээнүүд байдаг вэ?

ЗУРГАА. АППЛИКЭЙШН ТОХИРГОО-той холбоотой

- 6.1 Биометрик тохиргоо гэж юу вэ?
- 6.2 Social Pin-ээ яаж солих вэ?
- 6.3 Өнгө солих
- 6.4 Хэл солих
- 6.5 Холболт салгах

ДОЛОО. КАРТЫН ТОХИРГОО-той холбоотой

- 7.1 Картын тохиргоо гэж юу вэ?
- 7.2 Дебит виртуал карт гэж юу вэ?
- 7.3 Кредит виртуал карт гэж юу вэ?
- 7.4 Лоялти карт гэж юу вэ? Ямар картууд холбож болох вэ?
- 7.5 SocialPay NFT гэж юу вэ?
- 7.6 Голомт банкны карт хэрхэн захиалах вэ?
- 7.7 Бусад банкны картаа холбож ашиглах вэ?
- 7.8 Лоялти цэсэнд юу байдаг вэ?

НЭГ. SOCIALPAY аппликэйшн ерөнхий ойлголттой холбоотой

1.1 SocialPay гэж юу вэ?

- Утасны дугаар ашиглан бусад руу мөнгө шилжүүлэх, бусдаас мөнгө нэхэмжлэх боломжтой, санхүүгийн харилцааг хамгийн хялбараар шийдэх дижитал хэтэвч.

1.2 Үйлчилгээний нөхцөл

- SocialPay аппликэйшн ашиглах, SocialPay-тэй хэрэглэгч рүү мөнгө шилжүүлэх, нэхэмжлэхэд шимтгэл, хураамж байхгүй.
- “Сошиал данс”-нд холбосон харилцах данс Голомт банкны ерөнхий нөхцөлийн дагуу бусад банкны данс руу гүйлгээ хийх үед шимтгэл суутгагдана.

1.3 Аппликэйшн хэрхэн татаж авах вэ?

- App Store /Play Store → Search хэсэгт → SocialPay гэж бичиж хайх → Get, Install /Free, Install товч дарж татаж авна.

1.4 Хэрхэн бүртгүүлэх вэ?

- Та өөрийн гар утас App store, Play store-с SocialPay аппликэйшнийг татаж авна.
- “Бүртгүүлэх” товчийг дарж зааврын дагуу хувийн мэдээллээ оруулан SocialPay-г ашиглах боломжтой болно.
 - Голомт банкны интернэт банк хэрэглэдэг бол нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан нэвтрэх;
 - Голомт банкны дансгүй бол өөрт ойр байрлах дурын салбарт хандан интернэт банкны бүртгэл хийлгэсний дараа SocialPay ашиглах боломжтой болно.

*Хэрэв танд SocialPay нэхэмжлэх ирсэн бол SocialPay бүртгэл хийсний дараа автоматаар танд харагдах болно.

1.5 Гадаад улсын иргэн онлайнаар бүртгүүлж болох уу?

Зөвхөн Монгол улсын иргэд онлайнаар бүртгүүлэх боломжтой. Гадаад улсын иргэн салбарт хандан интернэт банк нээлгэж, SocialPay аппликэйшн ашиглах боломжтой болно.

1.6 Ямар сувгуудаар дамжуулан онлайнаар бүртгүүлэх боломжтой вэ?

- egolomt.mn
- SocialPay аппликэйшн
- Киоск төхөөрөмж /Иргэний үнэмлэх/

1.7 Хэрхэн нэвтрэх вэ?

- Банканд бүртгэлтэй гар утасны дугаарт ирсэн OTP буюу нэг удаагийн кодыг оруулан нэвтрэнэ.
- Хэрэв та Интернэт банк ашигладаг бол интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан нэвтрэнэ.

1.8 Сошиал данс гэж юу вэ?

- SocialPay аппликэйшн ашиглан төлбөр тооцоо хийхээр холбосон дансыг хэлнэ.

*Танд 1-с олон харилцах данс байдал бол сошиал дансыг сольж ашиглах боломжтой.

1.9 SocialPay-д ямар данс холбож болох вэ?

- Зөвхөн харилцах данс холбох боломжтой. Хадгаламжийн болон зээлийн данс холбох боломжгүй гэсэн үг юм.

1.10 Сошиал пин гэж юу вэ?

- SocialPay аппликэйшнаар гүйлгээ хийх үед ашиглагдах 4 оронтой нууц код. Уг кодыг харилцагч та өөрөө үүсгэн, солих боломжтой. Энэхүү код нь таны санхүүгийн мэдээлэл, гүйлгээний нууцлалыг хангах хэрэгсэл тул бусдад алдахаас сэргийлнэ үү.

1.11 SocialPay аппликэйшнаар шилжүүлсэн мөнгө болон нэхэмжлэхийн талаар нөгөө хүн маань яаж мэдэх вэ?

- SocialPay ашиглан хийж буй бүх төрлийн гүйлгээнд шилжүүлэгч болон хүлээн авагчид notification болон мессеж гэсэн 2 сувгаар мэдээлэл очно.

1.12 Нэхэмжлэхийг хэдэн хүн рүү илгээж болох вэ?

- Хамгийн ихдээ нэг удаад 10 хүн рүү зэрэг ижил дүнтэй нэхэмжлэх илгээх боломжтой.

1.13 SocialPay аппликэйшнаар мөнгө нэхэмжлэхэд лимит байгаа юу?

- Нэг удаад илгээх нэхэмжлэлийн дүн 100₮ - 5,000,000₮ төгрөг байна. Та нэхэмжлэх илгээх дээд дүнгээр нэг өдөрт хэдэн удаа ч нэхэмжлэл илгээх боломжтой.

ХОЁР. SOCIALPAY аппликэйшн хэрэглээтэй холбоотой

2.1 SocialPay-д бүртгүүлсэн гар утасны дугаарыг яаж өөрчлөх вэ?

- SocialPay аппликэйшны “Тохиргоо” цэс “Утасны дугаар солих”-г хэсгээр утасны дугаараа шинэчлэх боломжтой.

2.2 Бусад банкны дансны мөнгө шилжүүлэхэд зөвхөн дугаарыг мэдэж байвал шилжүүлэг хийж болох уу?

- Хүлээн авагч банк болон дансны дугаараар гүйлгээ хийх боломжтой. Гүйлгээ хийх мөнгөн дүн, хүлээн авагч банк, дансны дугаарыг оруулна. Банк хоорондын гүйлгээний шимтгэл: 200₮

2.3 Утасны дугаараар мөнгө шилжүүлэхэд тухайн хүнийхээ мэдээллийг хадгалсан байх шаардлагатай юу?

- Шаардлагагүй. Та зөвхөн хүлээх авах хүний утасны дугаарыг бичиж гүйлгээг хийнэ.
- “Тогтмол шилжүүлдэг” хэсэгт байрлах жагсалтаас сонгон гүйлгээг хялбараар хийнэ.

2.4 Олон данстай хүн рүү мөнгө шилжүүлбэл аль данс руу нь орох вэ?

- Хүлээн авагч талын SocialPay-д холбосон дансанд орно.

2.5 Гар утасны дугаараа сольж өөр дугаар баривал над руу шилжүүлсэн мөнгө өөр хүнд очих уу?

- Үгүй, хүлээн авч буй гар утасны дугаар таны данстай холбогдсон тул таны данс руу шууд орно.

- Харин таны ашиглаж байсан хуучин дугаарыг өөр хүн аппликэйшнд бүртгүүлбэл таны данснаас холболт шууд сална. Иймээс та гар утасны дугаарыг сольсон бол аппликэйшн ашиглан тухай бүр шинэчилнэ үү.

2.6 Буруу утасны дугаарт мөнгө илгээвэл яах вэ?

- Та мөнгө илгээхийн өмнө хүлээн авагчийн нэрийг шалгасны дагуу мөнгө илгээж байхыг зөвлөе. Таны гар утсан дээр бүртгэлтэй дугаарын жагсаалтаас хүлээн авагчийг сонгох нь буруу дугаарт мөнгө илгээх эрсдэлийг бууруулна.
- Хэрэв та буруу дугаарт мөнгө шилжүүлсэн бол Голомт банкны 1800-1646 дугаарт хандана уу.

2.7 Миний хэрэглээний төлбөрийн мэдээлэл SocialPay аппликэйшнд бүртгэлтэй гар утасны дугаарт ирэх үү?

- Төлбөрийн мэдээлэл SocialPay-д бүртгэлтэй гар утасны дугаарт очих бөгөөд нэхэмжлэл хэсэгт харагдана.

2.8 Сошиал дансандаа мөнгөгүй бол яаж орлого хийх вэ?

- Та интернэт банк эсвэл смарт банк аппликэйшн рүү нэвтрэн өөрийн данс хооронд гүйлгээ хийж сошиал дансандаа орлого нэмж болно.
- Бусад банкны данснаас Сошиал дансандаа мөнгө шилжүүлэн орлого хийх боломжтой.

2.9 Өдөрт хийх гүйлгээний лимитийг яаж нэмэгдүүлэх вэ?

- Орлого хүлээн авахад лимит байхгүй.
- SocialPay аппликэйшн ашиглан өдөрт 100₮ - 5,000,000₮ төгрөг хүртэл гүйлгээ хийх боломжтой.

Дараах сувгуудыг ашиглан давхар гүйлгээ хийх боломжтой.

- www.egolomt.mn ашиглан өдөрт 20 сая хүртэл дүнгээр гүйлгээ хийж болно. Хэрэв та гүйлгээний эрх нэмэгдүүлэх бол egolomt.mn “Хүсэлт илгээх” цэсээр эрх нэмэх хүсэлт илгээх эсвэл Голомт банкны дурын салбарт хандана.

2.10 Дансны хуулга, сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээллээ яаж харах вэ?

- SocialPay аппликэйшны баруун дээр байрлах гүйлгээний түүх цэсээр дамжуулан гүйлгээ хийсэн хүмүүсийн жагсаалтаас харах боломжтой. Гүйлгээний түүх харах хэрэглэгчийг сонгон SocialPay-р хийсэн гүйлгээний түүхийг харах боломжтой.
- Та интернэт банк, смарт банк аппликэйшн ашиглан SocialPay-д холбосон дансны хуулгаар орлого зарлагын мэдээллийг харах боломжтой.

ГУРАВ. SOCIALPAY аппликэйшн дээр гарч болзошгүй асуудал, хязгаарлалт, алдаатай холбоотой

3.1 Social Pin кодыг мартвал яах вэ?

- SocialPay аппликэйшнаас өөрийн холболтыг салгаж дахин нэвтрэх үед Social Pin хэсэгт байрлах “Мартсан?” товч дээр дарж сэргээн авах боломжтой.

3.2 Гар утсаа гэсэн эсвэл хулгайд алдсан тохиолдолд миний дансыг гадны этгээд ашиглах боломжтой юу?

- Хэрэв та гар утсаа алдсан бол өөр төхөөрөмжөөс дахин нэвтрэн орж банкны аппликэйшн дээр ашигладаг бүх нууцлалын мэдээллийг (*Нэвтрэх нэр, нууц үг, Social Pin*) солихыг зөвлөж байна. Ингэснээр та өөрийгөө санхүүгийн эрсдэлээс хамгаалж чадна.

3.3 Бүртгүүлсэн гар утасны дугаар маань өөр хүний данстай холбоотой байвал яах вэ?

- Та өөрийн бүртгэлийг шинэчлэхэд өмнөх хэрэглэгчийн данснаас утасны дугаарын холболт салж, таны данстай холбогдох болно.

ДӨРӨВ. ОНЛАЙН БҮРТГЭЛ ерөнхий ойлголттой холбоотой

4.1 Онлайн бүртгэл гэж юу вэ?

Голомт банканд дор хаяж нэг данстай харилцагч нь онлайн сувгаар дамжуулан өөрийн хувийн мэдээллүүдийг зааврын дагуу оруулж, баталгаажуулалт хийснээр интернэт банк эсвэл SocialPay-д бүртгүүлэх боломжтой үйлчилгээ юм.

Онлайн суваг:

- egolomt.mn
- SocialPay аппликэйшн
- Киоск төхөөрөмж

4.2 Онлайн бүртгэлийн онцлог

- Онлайн бүртгэл баталгаажих үед танд харилцах данс шинээр нээгдэж SocialPay үйлчилгээний эрх автоматаар үүснэ.

4.3 Үйлчилгээний нөхцөл

- Онлайнаар харилцагчаар бүртгүүлэх болон Интернэт банк үйлчилгээний эрх нээлгэхэд ямар ч шимтгэл хураамжгүй.
- Шинээр нээгдэж буй харилцах данс нь Голомт банкны ерөнхий нөхцөлийн дагуу байна.

4.4 Ямар сувгуудаар дамжуулан онлайнаар бүртгүүлэх боломжтой вэ?

- egolomt.mn
- SocialPay аппликэйшн
- Киоск төхөөрөмж

4.5 Гадаад улсын иргэн онлайнаар бүртгүүлж болох уу?

- Гадаад улсын иргэн заавал салбарт хандан интернэт банк нээлгэж, SocialPay аппликэйшн ашиглах боломжтой.

4.6 Онлайнаар бүртгүүлэх хүсэлтэд маань хариу өгөхгүй бол яах вэ?

- Бид таны мэдээллийг баталгаажуулан ажлын өдөр 2-3 өдөрт хариу өгнө. Онлайн бүртгэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Голомт банкны 1800-1646 дугаарт хандан авна уу.

ТАВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ-тэй холбоотой

5.1 Нэмэлт үйлчилгээ цэсэд ямар үйлчилгээ байдаг вэ?

SocialPay “Нэмэлт үйлчилгээ” цэс нь онцлох үйлчилгээ болон Мини аппликэйшны жагсаалт хэсгээс бүрдэнэ.

Онцлох үйлчилгээ:

- **Машин:**
Та автомашины улсын дугаарыг оруулан татвар, торгууль, зогсоолын төлбөрийн нэхэмжллийг шалгаж нэг дороос төлөх боломжтой.
- **Umoney:**
Umoney автобусны картаа уншуулан үлдэгдэл харах болон цэнэглэх боломжтой.
- **Гар утас:**
Өөрийн болон бусдын гар утасны дугаарыг оруулан нэгж, дата, утасны төлбөр төлөх зэрэг үйлчилгээг нэг дороос авах боломжтой.
- **Байр:**
Та хэрэглэгчийн кодыг оруулан цахилгаан, СӨХ контор, орон сууц, интернэт кабелийн төлбөр төлөх боломжтой ба сар бүр тогтмол нэхэмжлэл хүлээн авах тохиргоог хийж ашиглах боломжтой.

5.2 “Хамт олон” үйлчилгээ гэж юу вэ?

SocialPay “Хамт олон” цэсийг ашиглан ажлын хамт олон болон найз нөхдийн дунд хуримтлал үүсгэн ашиглах боломжтой. Хуримтлал татах өдөр болон мөнгөн дүнг тохируулан нэхэмжлэл илгээж нэг дансанд мөнгөн хуримтлуулал үүсгэх, хянах боломжтой үйлчилгээ юм.

- **Хамт олны данс гэж юу вэ?**
Хамт олон шинээр үүсгэх үед хамт олны хуримтлал цуглуулах данс шинээр нээгдэнэ. “Хамт олон” үйлчилгээг идэвхжүүлж нээсэн хүн админ болох бөгөөд дансыг бүрэн захиран зарцуулах эрхтэй байна.
- **Хамт олны админ ямар эрхтэй вэ?**
Админ нь дараах үйлдлийг хийх эрхтэй ба хамт олон дунд нэг л хүн админ байна.
 - 1 Хамт олонд гишүүн нэмэх, хасах
 - 2 Хамт олны данснаас зарлага гаргах
 - 3 Хамт олон руу нэхэмжлэл илгээх
 - 4 Хамт олныг устгах буюу дундын дансыг хаах
- **Хамт олонд гишүүн нэмэх, хасах**
Гишүүн нэмэхдээ тухайн хүний SocialPay-д бүртгэлтэй гар утасны дугаарыг оруулан гишүүнээр элсэх хүсэлтийг илгээнэ. Шинэ гишүүн нь ирсэн хүсэлтийг зөвшөөрснөөр хамт олонд нэгдэх юм.
Хамт олны жагсаалтаас хасах хүний мэдээлэл дээр дарж хасах үйлдлийг хийнэ.
- **Хамт олны данснаас зарлага гаргах**
Хамт олны дансанд хуримтлуулсан мөнгийг админ өөрийн Сошиал данс руугаа авах боломжтой эсвэл өөр хүн рүү шилжүүлэх боломжтой.
- **Хамт олон руу нэхэмжлэл илгээх**
Нэхэмжлэл нь админы хийсэн тохиргооны дагуу сар бүрийн тогтсон өдөр авто илгээгдэнэ. Мөн админ хүссэн үедээ хамт олны гишүүд руу нэхэмжлэл илгээх боломжтой байна.
- **Хамт олноо хаах буюу дундын дансаа хаах**
Админ хамт олныг хаах үед дундын данс хаагдана. Данс хаах шимтгэл: 1000₮

5.3 Хүслийн хадгаламж гэж юу вэ?

Хүслийн хадгаламжаар дамжуулан харилцагч нь хугацаатай хадгаламжийн данс нээх боломжтой бөгөөд 1 сар – 24 сар хүртэлх хугацаатай байна. Хүслийн хадгаламж нь Голомт банкны энгийн хугацаатай хадгаламжийн ерөнхий нөхцөл дагуу хадгаламжийн хүү тооцогдоно.

5.4 Найзаа уривал ямар урамшуулалтай вэ?

SocialPay-д бүртгэлгүй харилцагчийг найзаар урьж бүртгүүлээд урамшуулал авах боломжтой.

Урамшуулал: Уригдсан болон урьсан найз тус бүр 1,000₮

Урамшуулал авах нөхцөл: Таны урьсан найз урилгын дагуу бүртгэл үүсгэн амжилттай нэвтрэх

5.5 Мини апп жагсаалт хэсэгт ямар үйлчилгээнүүд байдаг вэ?

Харилцагч таны өдөр тутмын хэрэгцээнд нийцэх 30 гаруй аппликэйшн Мини апп цэсэд байрлах бөгөөд хүссэн үйлчилгээг хамгийн хялбараар авах боломжтой.

- Даатгал:
 - Мандал даатгал
 - Миг даатгал
- Энтертаймент:
 - Zero.mn
 - Ticket.mn
 - #СТА
- Хандив:
 - Ид шидийн орон
 - Зүрх мартаггүй
 - Энгийн мөрөөдөл
- Хувьцаа, арилжаа:
 - Голомт Капитал ҮЦХК
- Эрүүл мэнд:
 - Eclinic
- Зорчигч тээвэр:
 - Автобус тээвэр
 - Төмөр зам
 - Нислэг
 - Тапатрип
 - Эрдэнэт автобус тээвэр
- Онлайн дэлгүүр:
 - Wellbee
 - Emart
 - Emonos
 - Zochil shop
 - Shoppy.mn
 - Next electronics
 - Made in Mongolia
 - Flower fairy
 - Techstore
 - Star phone
 - Bananamall
- Амралт, зугаалга:
 - Ihotel.mn
 - Joinme.mn

ЗУРГАА. АППЛИКЭЙШН ТОХИРГОО-той холбоотой

6.1 Биометрик тохиргоо гэж юу вэ?

SocialPay аппликэйшн хэрэглэх үед бүх төрлийн баталгаажуулалт хийх хурууны хээ болон царай таних тохиргоог асаах, унтраах зориулалттай үйлчилгээ юм.

**Та энэхүү үйлчилгээг идэвхжүүлэхээс өмнө таны гар утасны биометрик тохиргоонд бусад хүний хурууны хээ болон царай бүртгэлтэй байгаа эсэхийг шалгана уу. Хэрэв бүртгэлтэй байгаа бол бусад хүний бүртгэлийг устгасны дараа энэхүү тохиргоог идэвхжүүлэн ашиглахыг зөвлөж байна.*

6.2 Social Pin-ээ яаж солих вэ?

Хэрэглэгч цэс руу орж Social Pin солих товч дээр дарна. Ашиглаж буй Social Pin оруулан шинээр үүсгэн ашиглах боломжтой. Хэрэв та Social Pin мартсан бол аппликэйшны холболтыг салган, дахин нэвтрэх үед Social Pin оруулах хэсэгт байрлах “Мартсан?” товч дээр дарж сэргээнэ үү.

6.3 Өнгө солих

SocialPay танд 8 төрлийн өнгө бүхий theme санал болгох бөгөөд та өөрийн аппликэйшнийн өнгийг сонгон, сольж ашиглах боломжтой.

6.4 Хэл солих

Англи, Монгол хэлний сонголттой. “Тохиргоо” цэсэд байрлах хэл солих товч дээр дарснаар хэл сольж ашиглах боломжтой.

6.5 Холболт салгах

SocialPay аппликэйшнаас холболт салган гарах боломжтой.

ДОЛОО. КАРТЫН ТОХИРГОО-той холбоотой

7.1 Картын тохиргоо гэж юу вэ?

SocialPay “Картын жагсаалт” цэс дотор таны бүх картуудыг харуулах бөгөөд карт нуух болон жагсаалтад харагдах дарааллыг нь өөрчлөн сольж тохиргоо хийх боломжтой.

7.2 Дебит виртуал карт гэж юу вэ?

Харилцагчид олон улсын гүйлгээний эрхтэй Master, UnionPay, Visa гэсэн 3 сүлжээний дебит виртуал картаас сонгон шинээр үүсгэн ашиглах боломжтой. Картын дэлгэрэнгүй мэдээллийг ашиглан гадаад болон дотоодоос худалдан авалт хийх, өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах бүрэн боломжтой.

- Карт блок хийх:
 - Виртуал дебит картын мэдээллийг алдах тохиолдолд картыг блок хийж, ашиглагдах боломжгүй болгож болно.
- Карт нөхөн авах:
 - Блок хийсэн картыг нөхөн авах буюу виртуал дебит картыг шинээр үүсгэн авах боломжтой.
- Карт сунгах:

- Виртуал дебит картын хугацаа дууссан тохиолдолд 4 жилийн хугацаатай дахин сунгагдана.

7.3 Виртуал кредит карт гэж юу вэ?

100,000 төгрөгийн эрхтэй виртуал кредит картыг зөвхөн SocialPay аппликейшнаар дамжуулан ашиглах ба дараах үйлдлүүдийг хийх боломжтой байна.

- Карт идэвхжүүлэх
 - Виртуал кредит картыг идэвхжүүлэхдээ үйлчилгээний нөхцөл, гэрээтэй танилцаж баталгаажуулснаар карт идэвхэжнэ.
- Картаас шилжүүлэг хийх
 - Виртуал кредит картаас өөрийн сошиал данс руу мөнгө шилжүүлэн ашиглах боломжтой.
- Виртуал кредит картын төлбөр хийх
 - Картын төлбөр төлөх болон карт руу орлого хийх боломжтой байна.
- Гүйлгээний түүх
 - Картын орлого, зарлагын түүх нь гүйлгээ хийсэн огноотой хамт харагдана.

7.4 Лоялти карт гэж юу вэ? Ямар картууд холбож болох вэ?

UPOINT, Сансар, Имарт, Номин, Өргөө, Efes, Оргил, Good price болон Интерномын хөнгөлөлтийн лоялти картуудыг холбож болно.

7.5 SocialPay NFT гэж юу вэ?

Харилцагч нь SocialPay NFT-тэй бол Mongol NFT хаягаараа дамжуулан нэвтэрч NFT-ээ холбох боломжтой байна. NFT-ээ холбосноор буцаан олголт, купон гэх мэт тогтмол авах боломжтой урамшууллын мэдээллийг авах юм.

7.6 Голомт банкны карт хэрхэн захиалах вэ?

SocialPay “Хэтэвч” цэс баруун дээр байрлах + нэмэх товч дээр дарна. Захиалах картын төрлийг сонгож картыг хүлээн авах салбарыг сонгоно. Картын захиалга хийсэн өдрөөс хойш ажлын 3-4 хоногийн дараа сонгосон салбар таны захиалсан карт очно.

7.7 Бусад банкны картаа яаж холбож ашиглах вэ?

- SocialPay “Хэтэвч” цэсний баруун дээр байрлах + нэмэх товч дээр дарж “Банкны карт” хэсгийн холбох товчийг дарж бусад банкны картыг холбоно. Ингэснээр та худалдан авалт хийх үедээ бусад банкны аппликэйшн руу оролгүй SocialPay ашиглан төлбөр тооцоо хийх үедээ сонгон ашиглах боломжтой.

7.8 Лоялти цэсэд юу байдаг вэ?

- Лоялти цэсээр дамжуулан Голомт банкнаас зарласан нийт урамшуулалт хөтөлбөрүүдийн мэдээллийг нэг дороос авах боломжтой бөгөөд та өөрийн лоялти дансны мэдээлэл, купон урамшуулал, сугалааны мэдээллийг нэг дороос авах боломжтой.
- **Ямар төрлийн хөтөлбөр болон урамшуулал байдаг вэ?**
 - **Лоялти оноотой хөтөлбөр:** Бүх төрлийн төлбөр тооцоо, үйлчилгээнд суурилан оноо тооцоолон олгох зорилготой хөтөлбөр.
 - **Сугалаат хөтөлбөр:** Бүх төрлийн төлбөр тооцоо, үйлчилгээ, үйлдэл дээр суурилан сугалаа олгох зорилготой хөтөлбөр.

- **Буцаан олголттой хөтөлбөр:** Картын бүтээгдэхүүн дээр суурилан худалдан авалтын тодорхой хувийг тооцон буцаан олголт өгөх зорилготой хөтөлбөр.
- **Купон эрхийн бичигтэй хөтөлбөр:** Купон олгох болон лояалти оноог ашиглан купон худалдан авах зорилготой хөтөлбөр.